227

# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

# ЗАРЛИГ

1977 он 3 дугаар сарын 16 өдөр. Дугаар 64

Улаанбаатар хот

## СУМ, ХОРОО ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТУХАЙ

Атрын сангийн аж ахуйнуудыг шинээр байгуулсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс

ТОГТООХ НЬ:

1.Дор дурдсан сум, хороог шинээр байгуулсугай:

а/ Төв аймгийн "Залуучууд" сангийн аж ахуйг харьяалсан Цээл сум, төв нь "Оргил" мөн "Хар-эрэг" сангийн аж ахуйг харьяалсан Сүмбэр сум, төв нь "Жавхлант";

б/ Сэлэнгэ аймгийн "Номгон" сангийн аж ахуйг харьяалсан Сайхан сум төв нь "Номгон", "Баянхараат" сангийн аж ахуйг харьяалсан Жавхлант сум, төв нь "Жаргалант", "Найрамдал" сангийн аж ахуйг харьяалсан Цагааннуур сум, төв нь "Хуурч";

в/ Улаанбаатар хотын "Партизан" сангийн аж ахуйг харьяалсан Партизаны хороо, төв нь "Жаргалант".

2.Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум шинээр байгуулсантай холбогдуулан Зэлтэрийн сангийн аж ахуйг харьяалсан Цагааннуур сумыг Түшиг сум гэж өөрчлөн нэрлэсүгэй.

3. Шинээр байгуулагдах сум, хорооны АДХ-ын сонгуулийг энэ оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Ням гаригт явуулахыг холбогдох аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаадад даалгасугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга (Ю. ЦЭДЭНБАЛ)

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга (Ц. ДҮГЭРСҮРЭН)

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц. ГОТОВ)

Тэргүүлэгч гишүүн:

(С. БАТАА)
(Д. ЕНДОНДҮЙЧИР)
(Н. ЛУВСАНРАВДАН)
(Г. ОЧИРБАТ)
(С. УДВАЛ)
(Ч. ПҮРЭВЖАВ)
(Л. ТҮДЭВ)